



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 05 өдөр

Дугаар А/504

Хэрлэн сум

Шагналд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушгалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалт, Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоолоор батлагдсан "Аймаг нийслэлийн Засаг даргаас олгох шагналын нийтлэг тодорхойлолт", аймгийн Засаг даргын 2003 оны А/99, 2015 оны А/511 тоот захирамжыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий нутгийн хөгжлийн төлөө онцгой амжилт гаргасан иргэдийг шагнах зорилготой аймгийн "Хүндэт тэмдэг" болон "Хан Хэнтийн алдартан тэмдэг"-ийг хийлгэх зардалд 14,430,000 (арван дөрвөн сая дөрвөн зуун гучин мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын нөөц сангийн урьдчилан төлөвлөх боломжгүй нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2022  
оны... дүгээр сарын...-ны  
..... дугаар захирамжийн хавсралт

Хөрөнгө зарцуулалтын тооцоо

Бараа материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ
Хан Хэнтийн алдартан медаль	ш	400	19,500	7,800,000
Үнэмлэх	ш	300	2,300	690,000
Хүндэт тэмдэг	ш	300	17,500	5,250,000
Үнэмлэх	ш	300	2,300	690,000
Нийт дүн				14,430,000